

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРААС ХӨРӨНГИЙГ
ХУДАЛДАХ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР**

Дуудлагын худалдаа зохион байгуулах хэлбэр: Нээлттэй.

Дуудлагын худалдаа болох өдөр: 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 11:00 цагт.

Баримт бичиг хүлээн авах хугацаа: Дуудлага худалдаа явагдахаас 1 цагийн өмнө буюу 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 10:00 цаг хүртэл явагдана.

Иргэн дуудлагын худалдаанд оролцохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт;
2. Иргэний үнэмлэхийн хуулбар;
3. Дэнчин тушаасан баримт;
4. Дуудлагын худалдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөө оролцуулах бол нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэл;
5. Хэрэв зөвлөхийн хамт оролцох бол зөвлөхийн иргэний үнэмлэхийн хуулбар;
6. Дэнчинг буцаах мэдээлэл /банкны нэр, данс эзэмшигчийн нэр, дансны дугаар/.

Хуулийн этгээд дуудлагын худалдаанд оролцохдоо дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

Үүнд:

1. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт гаргах;
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
3. Дэнчин тушаасан баримт;
4. Хуулийн этгээдийг төлөөлж дуудлагын худалдаанд оролцох этгээдэд байгууллагаас олгосон итгэмжлэл;
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэх болон ажлын газрын үнэмлэхийн хуулбар;
6. Хэрэв зөвлөхийн хамт оролцох бол зөвлөхийн иргэний үнэмлэхийн хуулбар;
7. Хоёр болон түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэй тохиолдолд дуудлагын худалдаанд оролцох тухай хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөл;
8. Дэнчинг буцаах мэдээлэл /банкны нэр, данс эзэмшигчийн нэр, дансны дугаар/;

Дэнчингийн хэмжээ: Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн анхны дуудах үнийн 10 /арав/ хувь байна.

Дуудлагын худалдаанд хамгийн өндөр үнэ санал болгосон оролцогч ялагч болно. Дуудлагын худалдааны ялагч нь дуудлага худалдааны дүнгийн тэмдэглэлд тухайн өдөрт нь гарын үсэг зурах бөгөөд ажлын 5 өдрийн дотор үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг байгуулж, гэрээнд заасан хугацаанд хөрөнгийн үнийг бүрэн төлнө.

Дуудлагын худалдаанд оролцохыг хүсэгчид багц баримт бичгийн үнэ 30,000 төгрөг (Хөрөнгийн зурагт танилцуулга, хүсэлт гаргах маягт, гэрчилгээний хуулбар, дэнчинг буцаах маягт, дэг г.м)-ийг доорх дансанд шилжүүлж, тухайн хөрөнгийн талаарх мэдээллийг авснаар дуудлагын худалдаанд оролцох боломжтой болно.

Хүлээн авагч банк: Төрийн банк

Хүлээн авагчийн нэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Дансны дугаар: MN720034 106000021689

Гүйлгээний утга: Овог нэр /Байгууллага нэр/, регистрийн дугаар

Дуудлагын худалдаа зохион байгуулах хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу 13/1, Нийгмийн даатгалын ерөнхий газар, 405 тоот.

Жич: Нийгэмд үүсэх хөл хорио болон бусад давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан дуудлага худалдаа явагдах өдөр, цагт өөрчлөлт орох бол тухайн үед зарлан мэдээлнэ.

Холбоо барих утас: 90010777, 99181086, 88136098

Нээлттэй дуудлагын худалдааны хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгө эзэмшигч	Байршил, хаяг	Зориулалт	ҮҮХ-ийн гэрчилгээний дугаар	Хэмжээ (м.кв)	Хөрөнгийн үнэ (төгрөгөөр)
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	УБ хот, Хан-Уул дүүрэг, 4- р хороо, Нүхтийн ам, Нүхтийн зам гудамж, 24/3 тоот	Амины орон сууц	Ү-2206065792	290	760,000,000
2	Нийгмийн даатгалын ерөнхий газар	УБ хот, Хан-Уул дүүрэг, 4- р хороо, Нүхтийн ам, Нүхтийн зам гудамж, 24/4 тоот	Амины орон сууц	Ү-2206065793	290	760,000,000
3	Нийгмийн даатгалын ерөнхий газар	УБ хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, 17 дугаар байрны 13 давхарт	Оффис	Ү-2203029414	476.7	3,611,600,000
4	Нийгмийн даатгалын ерөнхий газар	ХУД, 21-р хороо, Буянт ухаа хороолол /17121/ архивчдын гудамж, 214 байр 401 тоот	Орон сууц	Ү-2206131587	141.01	513,000,000
5	Нийгмийн даатгалын ерөнхий газар	ХУД, 23-р хороо, Арцатын ам /17100/ 1544 байр 1206 тоот	Орон сууц	Ү-2206132113	83.2	297,000,000
6	Нийгмийн даатгалын ерөнхий газар	ХУД, 23-р хороо, Арцатын ам /17100/ 1544 байр 306 тоот	Орон сууц	Ү-2206132116	83.2	297,000,000
7	Нийгмийн даатгалын ерөнхий газар	ХУД, 23-р хороо, Арцатын ам /17100/ 1544 байр 105 тоот	Орон сууц	Ү-2206132119	69.2	247,000,000
8	Нийгмийн даатгалын ерөнхий газар	ХУД, 4-р хороо яармаг /17110/ наадамчдын Зам гудамж 405 байр 45 тоот	Орон сууц	Ү-2206070001	55.8	178,000,000
9	Нийгмийн даатгалын ерөнхий газар	СХД, 37-р хороо, ханын материал /18062/ үйлвэрчний эвлэлийн гудамж 52 байр 153 тоот	Орон сууц	Ү-2201071779	64.35	185,000,000
10	Нийгмийн даатгалын ерөнхий газар	БГД, 24-р хороо, үйлдвэрийн төвийн бүс /16030/ үйлдвэрийн гудамж 54/5 байр 1606 тоот	Орон сууц	Ү-2205083606	63.05	271,000,000
11	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, 6-р хороолол /15140/, Г.Бумцэнд гудамж 47/6 байр 309 тоот	Үйлчилгээ	Ү-2202030985	84.76	446,000,000